

“БОДЬ ДААТГАЛ” ХК-ИЙН ХЭ-ИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04 сарын 20

Улаанбаатар хот

“Бодь Даатгал” ХК-ийн ХЭ-ийн ээлжит хурал 2026 оны 04-р сарын 20-ны өдрийн 11:27 цагаас “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн www.agm.mn веб суурьтай цахим хаягаар дамжуулан цахим хэлбэрээр болж, Хурлын даргаар Гүйцэтгэх захирал А.Энхжаргал, удирдлагын багаас М.Мөнхбаатар, Ж.Наранцэцэг, ТУЗ-ийн дарга Б.Билэгт, ТУЗ-ийн гишүүн Г.Саруул, ТУЗ-н гишүүн Ш.Бэжид Тооллогын комиссын дарга Х.Сарангоо болон тооллогын комиссын бүрэлдэхүүн, Нарийн бичгийн дарга Ө.Батчимэг нарын бүрэлдэхүүнтэй оролцов.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. 2025 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас Ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
3. Дүрмийн сан нэмэгдүүлэх тухай асуудлыг хэлэлцэж, батлах;
4. Бодь даатгал ХК-н дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэж, батлах;
5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
6. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг батлах;

ТУЗ-н дарга Б.Билэгт: Нийт хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэнд хүргэе. Хурлын даргаар Гүйцэтгэх захирал А.Энхжаргал томилогдсон тул хурлыг удирдан явуулна уу.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Х.Сарангоо: Бодь даатгал ХК-н хувцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол, 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр, Улаанбаатар хот,

1. “Бодь Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд **205,510,132** ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй **26** хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрх бүхий **231,931,348** ширхэг хувьцааны **88.61%** болж байгааг хуралд оролцогчдод болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1, 69.2 дахь заалт, компанийн дүрмийн 7.4 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны **88.61%**-ийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Тооллогын комиссын дарга: Х.Сарангоо, Тооллогын комиссын гишүүн: Ж.Наранцэцэг, Ц.Наранзаяа, С.Дөлгөөн. Хурлын ирцийг танилцуулж дууслаа

Хурлын дарга А.Энхжаргал: Хурлын ирц бүрэн, хүчин төгөлдөр байгаа тул хувьцаа эзэмшигчдийн хурал албан ёсоор нээснийг мэдэгдье.

- Хурлын хэлэлцэх асуудлыг танилцуулав.

- Хурлын дэгийг баталснаар танилцуулав.

М.Мөнхбаатар: 1-р асуудал. Компаний 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулахад бэлэн болсон байна. Даатгалын зах зээлийн хувьд өнгөрсөн онд 8,4 хувиар өсч, 800

тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнийг 2021 онтой харьцуулан харвал 80,1 хувийн өссөн үзүүлэлттэй гарсан байна. Үүнээс харвал нийт 800 тэрбумын өсөлтийн 87,7 хувь 702,2 тэрбумыг ердийн даатгалын компаниуд эзэлж байна.

Хөрөнгийн бүтцийг аваад үзвэл 2025 оны жилийн эцсийн байдлаар хөрөнгө оруулалтын хэмжээ 57,1 хувийг эзэлж байна. 18,9 хувийг даатгалын хөрөнгө, 7,8 хувийг даатгалын авлага гэх мэтчилэн эзэлж байна. Эндээс харахад хөрөнгө оруулалт бол ихэнхи хувийг эзэлж байгаа нь манай компаний санхүүгийн тэнцэлд эерэг үзүүлэлт болж байна. Өөрийн хөрөнгийн бүтэц, өөрийн хөрөнгийн хэмжээг 16,7 хувь буюу өмнөх оноос 35 хувийн өсөлтийг үзүүлсэн байгаа.

Ингээд нийт төлөвлөгөөний биелэлтийг авч үзвэл 80,4 хувийн гүйцэтгэлтэй гарсан. 2025 оны цэвэр хураамжийн орлогын төлөвлөгөөний биелэлт 80,4 хувь буюу 29,1 тэрбумын төлөвлөгөөтэй байснаас 23,4 тэрбумыг хийсэн. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг холбогдох сувгаар нь авч үзвэл орон нутгийн хувьд 69,3 хувьтай, давхар даатгал АХА 78,3 хувьтай, иргэд 80 хувьтай, байгууллага, 84,8 хувьтай гэсэн гүйцэтгэлтэй гарсан.

Б.Билэгт: Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг уншиж танилцуулав. /Дэлгэрэнгүй тэмдэглэлд /

А.Энхжаргал: 2-р асуудал болох Ногдол ашиг хуваарилах тухай тогтоолыг уншиж танилцуулав./ Дэлгэрэнгүй тэмдэглэлд /

Ногдол ашиг хуваарилах ажлыг компаний удирдлагын баг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Дараагийн асуудал болох Компаний дүрмийн санг нэмэгдүүлэх асуудлыг хэлэлцэнэ.

Зохицуулагч компаний хувьд өнгөрсөн жил 2025 онд ердийн даатгал, урт хугацааны даатгалын компаний дүрмийн санг нэмэгдүүлэх чиглэл гараад байгаа. Хэдий батлагдаагүй ч цаашдын төлөвийн хувьд ердийн даатгалын компаний дүрмийн сангийн хэмжээг 10 тэрбумд хүргэх, урт хугацааны компаний дүрмийн санг 8 тэрбумд хүргэх төлөвтэй байна. Хэдий өнгөрсөн жил батлагдаагүй ч энэ жилдээ эсвэл дараа жилдээ ажил хэрэг болоод биежэх байх.

Дүрмийн санг нэмэгдүүлснээр бид хүний нөөцийн бодлогодоо шинэчлэл хийх, чадавхижуулах боломжтой болно. Үүнээс гадна сүүлийн үеийн техник, технологийн үсрэнгүй хөгжлийг компаний үйл ажиллагаанд нэвтрүүлэх, цаг үетэй хөл нийлүүлэн алхах боломжтой болно. Мөн салбарын эрсдэл даах чадвар сайжирснаар гадагшаа чиглэж буй мөнгөн урсгалыг татах боломжтой. Мөн даатгуулагчдын итгэлийг илүүтэй даах болно.

Тиймээс бид дүрмийн санг тодорхой хэмжээнд үе шаттайгаар нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзээд энэ жилийн ашигт ажиллагаа, хуримтлагдсан ашгаас нийт хоёр тэрбум таван зуун наян найман сая таван зуун арван зургаан мянга найман зуун наян төгрөгөөр нэмэгдүүлэх санал гаргаж байна. Ингэснээр нэрлэсэн нэгж хувьцааны үнэ 36 төгрөгт хүргэх боломжтой болно.

А.Энхжаргал: Бодь Даатгал ХК-н дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэе.

Компаний дүрэмд бид үндсэн гурван асуудлыг өөрчлөхөөр зорьсон. Үүнд бид нарын байрлаж буй энэхүү барилгын нэр албан ёсоор өөрчлөгдсөнтэй холбоотой компаний дүрэмд компаний хаяг, нэршилийг өөрчлөх хэрэгцээ шаардлага үүссэн. Нэрний хувьд Бодь цамхаг гэснийг Богд тауэр болж өөрчлөгдсөн. Тиймээс Компанийн дүрмийн 1.4 дэх заалтыг өөрчлөн найруулсан.

Дүрэмд оруулж буй хоёрдугаар өөрчлөлт бол өмнө нь танилцуулсан дүрмийн сан нэмэгдүүлэхтэй холбоотойгоор нэгж хувьцааны үнийг шинэчлэн оруулж байгаа. Дүрмийн 4.1-т заасныг дараах байдлаар өөрчлөн найруулав.

“Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу иргэдэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компаний хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компаний хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн 36 төгрөгийн нэрлэсэн үнэтэй хоёр зуун гучин таван сая гурван зуун арван есөн мянга долоон зуун арван мянган ширхэг энгийн хувьцаа байна” гэж заасан байгаа.

Дүрмийн дараагийн өөрчлөлт нь компаний дүрэмд зааснаар компаний гүйцэтгэх удирдлагыг гүйцэтгэх удирдлагын баг хэрэгжүүлнэ гэснийг компаний гүйцэтгэх удирдлагыг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ гэж өөрчлөн шинэчилсэн байгаа.

Компаний гүйцэтгэх удирдлагын баг нь тухай компаний үйл ажиллагаанаас хамааран 6 эсвэл 7 зарим компаниуд 8 хүн нэмэх нь ерөнхий нягтлан бодогчийг оруулан тооцдог. Эдгээр хүмүүстэй холбоотой аливаа нэг өөрчлөлт орсон тохиолдолд ялангуяа бид нар гүйцэтгэх удирдлагын багийг шинээр бүрдүүлэх, томилох, солих зэрэг тохиолдлуудад заавал санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авдаг зарчимтай байдаг. Одоогийн зохицуулалтаар бид ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны шийдвэрийг авч цааш нь хороонд уламжилдаг байгаа. Энэ нь манай үйл ажиллагаанд цаг хугацааны хувьд шийдвэр гаргахад удааширалтай, сайн нэр дэвшигч, хүний нөөцийг алдах зэрэг эрсдлийг үүсгэдэг. Нөгөө талаасаа хорооны үйл ажиллагаанд ч ачаалал үүсгэх сул талтай бөгөөд энэ талаар бодлого зохицуулагч байгууллагын зүгээс өөрчлөлт оруулах хүсэлтийг ирүүлж байсан. Эдгээр үндэслэлээр бид компаний дүрмийн 8.12.16 дахь заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулж байна.

Нэгт. ТУЗ нь компаний тухай хууль болон энэ дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд. Компаний салбар төлөөлөгчийн газар байгуулна. Энэ нь өмнө нь дурдсанчлан салбарын төлөөлөгчийн газар байгуулах асуудал нь хэдий ТУЗ-ийн хүрээнд шийдвэр гарч үйл ажиллагаа явагдаж байгаа хэдий ч түрүүн заасан заалтуудтай уялдуулаад салбаруудын удирдлага, менежер, салбарын захиралуудыг яаралтай шийдвэр гаргахад нэмэртэй тул өөрчлөлт оруулж байгаа юм.

Хоёрт. Удирдлагын багтай холбоотой зүйл заалтыг дүрмийн 12.2-т зааснаар дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулав. Үүнд. Компаний гүйцэтгэх удирдлагыг хувь хүн буюу гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ гэж өөрчлөн найруулсан байгаа. Мөн үүнтэй холбоотой дүрмийн 12.3, 12.6 болон 12.7 дахь заалтуудыг тус тус хасч байгаа. Үүнтэй холбоотойгоор гүйцэтгэх захиралын эрх, үүргийн дугаарлалтыг 12.5 болгон өөрчилсөн. Харин дээрхи заалтыг 12.5.1-т өөрчлөн найруулсан оруулсан байгаа. Хараат болон охин компани салбар төлөөлөгчийн байгуулах саналыг ТУЗ-т танилцуулж, батлах ба тэдгээрийн удирдлагын багийг гүйцэтгэх захирал томилох, чөлөөлөх, хөдөлмөрийн ба үр дүнгийн гэрээ байгуулах хэмээн өөрчлөн найруулсан.

Мөн дүрмийн 12.5.14-т дараах нэмэлт өөрчлөлт оруулсан байгаа. Удирдлагын багийг бүрдүүлж тэдгээрийн захиралуудыг томилж, чөлөөлж, хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээ байгуулах гэж өөрчлөн оруулсан. Мөн дүрмийн 13.1-т заасныг ТУЗ-ын дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх захиралын орлогч захирал, ерөнхий нягтлан бодогч, хараат болон охин компаниудын захиралуудыг компаний эрх бүхий албан тушаалтанд тооцно гэж шинэчлэн өөрчлөн найруулж байгаа. Эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь улсын бүртгэлийн газарт бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ. Дөрөвдүгээр асуудал: ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийн нэр дэвшигчдийн танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн хамт батлах байгаа. Бодь Даатгал ХК-ийн хараат бус гишүүдээр Б.Бүжинлхам, Э.Бямбажав, Л.Банзрагч нар ажиллаж ирсэн. Эдгээр гишүүдийн хугацааг үргэлжлүүлэн сунгахаар танилцуулж байна. Ердийн гишүүдийн хувьд Л.Болдохуяг, Б.Билэгт, Г.Саруул, Д.Даянбилгүүн, Ш.Бэжид, Ш.Сүхбаатар нарын бүрэлдэхүүнтэй ажилладаг. Эдгээр гишүүдийн хугацааг мөн адил сунган

ажиллуулах саналтайгаар танилцуулж байна. Та бүхэн хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудал танилцуулагдсаны дараагаар саналаа өгнө үү.

Тавдугаар асуудал: ТУЗ-ийн үйл ажиллагааны жилийн зардлыг хэлэлцэн батлах асуудлыг танилцуулъя. Бид энэхүү зардлыг шинэчлэн баталж байгаа нь ТУЗ-ийн дарга, ердийн болон хараат бус гишүүдийн цалингийн хувьд өөрчлөлт орсон бөгөөд сүүлийн 5,6 жилийн хугацаанд тогтмол зардалтай явж ирсэн байгаа. Хэдий тийм боловч сүүлийн жилүүдэд компаний үйл ажиллагаа хүрээгээ тэлж, нөхцөл байдал сайжирч байгаа тул эдгээр зардлуудыг нэмэх нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Мөн ТУЗ-ийн гишүүдийн сургалт, хөгжүүлэлтийн зардал нэмэгдэж орж ирсэн байна.

С.Дөлгөөн: Тооллогын комиссын санал өгөх заавар зааварчилгааг танилцуулав. Санал хураах үйл ажиллагаа 15 мин үргэлжилнэ.

А.Энхжаргал: Санал хураалтын хугацааг эхлүүллээ. Энэ хугацаанд хуралд оролцогчдоос ирүүлэх асуулт, хариултыг эхлүүлсэн байгаа.

Асуулт 1: “Ногдол ашгийн хэмжээг дараа жилээс нэмэгдүүлэх боломжтой юу?” гэсэн байна. Дараа нь хүсэлт болоод асуулт гэсэн байна. “Дараа жилийн хурлыг танхимаар хийх үү?” гэж асуусан байна.

А.Энхжаргал: Нэгдүгээр асуултад хариулахад “компаний ашигт ажиллагаа, цар хүрээ тогтмол өсөн нэмэгдэж байгаа. Энэ нь ашигт ажиллагаанд ч мөн адил эерэг нөлөөл үзүүлж байгааг Та бүхэн мэдэж байгаа. Компаний зүгээс хувьцаа эзэмшигчдийн энэхүү хүсэлтийг харгалзан үзээд ногдол ашгийн хэмжээг өнгөрсөн гурван жилийн хугацаан жил бүр тодорхой хэмжээнд тогмол нэмж хуваарилаж байсан. Энэ жилийн хувьд компаний дүрмийн санг нэмэгдүүлэх, компаний бодлогын хүрээнд шинэчлэх, чадавхижуулах шаардлагууд үүссэн тул өнгөрсөн жилийн дүнгээр ногдол ашиг олгохоор санал оруулсан байгаа. Мэдээж бид цаашид холбогдох тооцоо судалгаанд үндэслэн нэмэгдүүлэх бодлогыг баримталж ажиллана.”

М.Мөнхбаатар: Энэ тал дээр мэдээж хурлыг танхимаар зохион байгуулах бүрэн боломжтой. Гэхдээ бид технологийн дэвшлийг ашиглаад, тэгш хүртээмжтэй байдлыг хангахын тулд БИ ДИ Сек үнэт цаасны компанитай хамтран цахимаар зохион байгуулж байгаа. Мэдээж дараа, дараагийн хурлуудыг хувьцаа эзэмшигчдээс санал авч танхимаар зохион байгуулах боломжтой.

Асуулт: Ашигт ажиллагаанд нөлөөлсөн голлох хүчин зүйл юу вэ?

А.Энхжаргал: Ашигт ажиллагаанд гол хүчин зүйл нь бид өнгөрсөн жилийг 2024 онтой харьцуулахад чамлахааргүй өсөлттэй гарсан байгаа. Борлуулалт мэдээж тодорхой хэмжээнд нэмэгдсэн. Мөн хөрөнгө оруулалт, түүнийг удирдах бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд бараг 30 хувь нэмэгдсэн байгаа. Энэ нь мэдээж ашигт ажиллагаанд голлох нөлөөг үзүүлсэн. Түүнчлэн зардлын удирдлагыг маш амжилттай хэрэгжүүлсэн гэж үзэж байна. Хамгийн голлох хүчин зүйл нь нөхөн төлбөрийн зардал буурсан байгаа. Энэ зардал буурсан нь ашигт ажиллагаанд эерэгээр нөлөөлсөн гэж үзэж байна.

Б.Дөлгөөн: Санал хураалтын үр дүнг нэгтгэх 5 минутын хугацаа эхэллээ.

Асуулт: “Бодлого, стратегийн түвшинд 2026 онд хийгдэхээр төлөвлөгдөж байгаа ажлууд юу вэ?” гэсэн асуулт ирлээ.

А.Энхжаргал: Бодлого, стратегийн хүрээнд компаний санхүүгийн үр дүн, чадавхийг сайжруулах, төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх зэрэг эрсдэлд суурилсан бодлогыг хэрэгжүүлж ажиллаж ирсэн. Үүний үр дүнд компаний санхүүгийн нөхцөл байдал сайжирсан. Тэгэхээр бид энэ онд дараагийн жилүүдэд зах зээл дээр компаний байр суурийг өсгөх, өөрсдийн хүрээг тэлэх, өсөлт хөгжилтийг нэмэгдүүлэх стратегийг баримталж байгаа. Өмнө танилцуулснаар техник, технологийн дэвшлийг ашиглах, үүнтэй холбоотой хөрөнгө оруулалтуудыг хийснээр бүтээгдэхүүний хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлнэ гэж харж байгаа. Тиймээс бид 2026 оны зорилтуудыг 50-60 хувийн өсөлт хийхээр нилээн амбицтай төлөвлөж

байгаа. Шинэ бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлэх, одоогийн үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээг чанаржуулах зэрэг арга хэмжээг төлөвлөж байна.

Тооллогын комиссын дарга Х.Сарангоо : Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулъя.

Бодь Даатгал ХК-ийн саналын эрхтэй нийт 231,931,348 ширхэг хувьцаанаас 88.61% буюу 205,510,132 ширхэг хувьцаа эзэмшиж буй 26 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

НЭГ. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99% буюу 205,495,369 ширхэг хувьцаатай 18 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

ХОЁР. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг хэлэлцэн батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99% буюу 205,495,369 ширхэг хувьцаатай 18 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

ГУРАВ. Дүрмийн сан нэмэгдүүлэх шийдвэрийг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99% буюу 205,495,369 ширхэг хувьцаатай 18 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.9999% зөвшөөрсөн, 0.0001% татгалзсан, 0.00% түдгэлзсэн байна.

ДӨРӨВ. Бодь даатгал ХК-н дүрэмд өөрчлөлт оруулах шийдвэрийг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99% буюу 205,495,369 ширхэг хувьцаатай 18 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100.00% зөвшөөрсөн, 0.00% татгалзсан, 0.0001% түдгэлзсэн байна.

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.Үүнд:

ТАВ. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99% буюу 205,495,369 ширхэг хувьцаатай 18 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Ердийн гишүүдэд өгсөн санал:

1. Болдхуягийн Билэгт - 11.1118% - 205,507,199
2. Лувсанвандангийн Болдхуяг - 11.1117% - 205,507,099
3. Ганбаатарын Саруул - 11.1118% - 205,507,399
4. Данзангийн Даянбилгүүн - 11.1119% - 205,510,108
5. Ширчингийн Сүхбаатар - 11.1107% - 205,487,199
6. Шонуунорсонгийн Бэжид - 11.1107% - 205,487,019

Хараат бус гишүүдэд өгсөн санал: ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс

1. Батчулууны Бүжинлхам- 11.1107% - 205,486,899

2. Эрдэнийн Бямбажав - 11.1107% -205,486,899

3. Лхагвасүрэнгийн Банзрагч - 11.1102% - 205,478,500 тус тус санал авч эдгээр гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов.

Тооллогын комиссын дарга Х.Сарангоо, гишүүн Ж.Наранцэцэг, Ц.Наранзаяа, С.Дөлгөөн нар.

А.Энхжаргал: Тогтоолын төслүүдийг танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Тогтоол №1

1. Бодь Даатгал ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг дурдсугай.
2. Бодь даатгал ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт №1-т заасны дагуу батласугай

Тогтоол №2

1. Бодь даатгал ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 2,588,516,898, (Хоёр тэрбум таван зуун наян найман сая таван зуун арван зургаан мянга найман зуун ерэн найман) төгрөгөөр нэмэгдүүлэн нэг бүрийн нэрлэсэн үнийг 36 (Гучин зургаан) төгрөг болгон өөрчлөсүгэй,
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний өөрчлөлтийг дүрэмд тусган, дүрмийн өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороо, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал А.Энхжаргалд даалгасугай,

Тогтоол №3

1. Бодь даатгал ХК-ийн Дүрэмд орох өөрчлөлтийг Хавсралт №1-т заасны дагуу батласугай,
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, дүрмийг Санхүүгийн зохицуулах хороо, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал А.Энхжаргалд даалгасугай,

Тогтоол №4

1. Бодь даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Б.Бүжинлхам, Э.Бямбажав, Л.Банзрагч нарыг улируулан сонгосугай,
2. Бодь даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Л.Болдхуяг, Б.Билэгт, Г.Саруул, Д.Даянбилгүүн, Ш.Бэжид, Ш.Сүхбаатар нарыг улируулан сонгосугай,

Тогтоол №5

1. Бодь даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг “Хавсралт №1”- т заасны дагуу батласугай.

Хурал 13:07 минутад өндөрлөн хурлын дарга хурлыг хаав.

Хурлын дарга:

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

А.Энхжаргал

Ө.Батчимэг /...../

